

1944 оны 4 дүгээр сарын 4-нд анхны нь дугаар хэвлэгдэн гарсан «Пионерийн үнэн» сонин пионер сурагчдыг элбэг баян оюун ухаан, эрүүл чийрэг бие бийдэл, цэвэр ариун ёс суртахуунтай, хөдөлмөрч хичээнгүй, гоо зүйн өв тэгш хүмүүжилтэй, ард түмний хувьсгалт дайчин хөдөлмөрч баатарлаг уламжлалыг нэр төртэй үргэлжлүүлэгч, коммунист хүний сайн сайхан бүхнийг эзэмшигч болгон хүмүүжүүлэх намын программын зорилтыг биелүүлэх нэр төртэй үүргээ сайн биелүүлж байна. Өсвөрийн үеийг коммунист ёсоор хүмүүжүүлэх үүргээ нэр төртэй биелүүлсэн учир «Пионерийн үнэн» сонин 15 жилийн

ойгоороо БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шааг нагджээ.

Таван зуу гаруй сурвалжлах идэвхтэнтэй тус сонинны редакци өнгөрсөн

Манай орны бүх хүн амын 46 хувийг эзэлж байгаа 16 хүртлэх насны хүүхдэд зориулан гаргадаг «Пионерийн үнэн» сонинны захиалагчдын тоо одоо 132000 гаруй болж 15 жилийн өмнөх бу-

галантай тэмдэглэн өнгөрүүлээ.

«Пионерийн үнэн» сонин 30 жилийн ойгоо угтаж пионер сурагчдын дунд гар ба гэрэл зургийн уралдаан, «Миний сайхан аав ээж» зохион бичлэгийн уралдаан, «Э-

«Пионерийн үнэн» сонин анхны эрхлэгчээр ажиллаж байсан түүхийн ухааны доктор Г. Дэлэг мөн тус сонинд ажиллаж байсан ахмад сэтгүүлч Н. Цэвэнжав, ахмад зохиолч профессор Д. Цэгмэл, төрийн шагналт яруу найрагч Ц. Гайтав, Б. Явуухулан, Ч. Чимэд, эрдэмтэн зохиолч Л. Түлэв, П. Хорлоо, академич Ш. Нацагдорж, БНМАУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн А. Чойжилжав нарын зэрэг хөдөлмөрч соёлын цуутнуудыг төрүүлсэн «Пионерийн үнэн» сонин 30 жилийнхээ ойгоор БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн зарлигаар «Алтан гадас» одонгоор шагнагдлаа.

Б.ТОГООХҮҮ

БЯЦХАН УНШИГЧДЫН ДОТНЫ ЗӨВЛӨГЧ

жил өдөрт 15 захидал авч байсан бол энэ онд өдөрт 30—35 захидал тогтмол авч байна.

«Пионерийн үнэн» сонинд сурагчдын сурлага, ёс суртахуун, гоо зүйн хүмүүжил, шинжлэх ухаан техник, хууль зүйн мэдлэгт зориулсан 60 шахам булан ажиллаж байна.

юу 1959 оныхоос даруй 4 дахин өссөний гадна чанар үзэмж нь дээшилж 3—5 өнгөөр гарч байна.

Сонинны агуулга, бүтэц, хэл найруулга, зураг чимэглэл нь өдрөөс өдөрт улам сайжирч байгаа. «Пионерийн үнэн» сонинны 30 жилийн ойг манай пионер сурагчид баяр баяс-

рийн даалгавар, «Миний найз» хэлэлцүүлэг, эх орны тусгаар тогтнол, социалист бүтээн байгуулалтад, хүүхдийн гараар оруулсан үнэт хувь нэмрийг тодруулан олох «Эрэн сурвалжлах клуб», «Пионерийн идэвхтэн гэж хэнийг хэлэх бэ?» гэсэн бага хурал зохиожээ.

ТӨЛИЙГ СЭНСРЭХЭЭС СЭРГИЙЛЬЕ

Малын тарга, цаг агаарын тааламжтай нөхцөлд төл сайн бойжиж байгаа боловч энэ амжилтайд тайвширч төлд тавих анхаарал харууцлага суларч байгаагаас төлийг сэнсрүүлж хорогдуулах дутагдал бүрэн, Заамар, Сэргэлэн, Өндөрширээт, Жаргалант зэрэг сумдад гарч Баян-Өнжүүл сумын «Бадрахын буланд» байгаа 10 гаруй суурь ямар ч бэлтгэлгүй газар хоноо төлдүүлж байна.

Хөрвө төлийг эхтэй нь хамт бойжуулбал эхийгөө олон дахин гувшиж түүнийг ядраахын гадна явдлыг нь гүйцэлгүй өөрөө энэж турдаг.

Иймд хөрвөжсөн төлийг өглөө эхэд нь хөхүүлж хотондоо авч үлдээгээд нэмэгдэл тэжээлээр сайн тэжээж усалж хужирлах хэрэгтэй.

Орой малаа хотлохын өмнө эхтэй нь бэлчээрт нийлүүлж хөхүүдээд хотонд нь ирмэгц ялган хашаанд оруулна.

Хөрвө төлд сайн чанарын ногоон өвс, хивэг, өвсний ханд, нацагсан будаа, багсармал тэжээл зэргийг байранд нь хангалттай байлгавал зохино.

Энэ үед ус хамгийн чухал шаардлагатай.

Ус нь төлийн тэжээл боловсруулалтыг сайжруулж бодисын солилцоог түргэтгэхээс гадна биеэс хорт бодисыг гадагш зайлуулж чухал хэрэгцээт эрдэс болон бусад бодисыг уусган шингээж би-

сийн дулааныг тогтмол байлгана.

Иймд төлийн байранд 10—20 градусын бүлээн цэвэр усыг байнга байлгавал зохино.

Төлийг услах гэж эхтэй нь хамт ус руу тууж аваачих нь түүнийг ядрааж цангаахад хүргэнэ.

Хөрвөжилтийн өсөлт хөгжилтөд амин чухал зүйл бол эрдэсийн бодис юм.

Эрдэс бодис дутагдал төлийн өсөлт хөгжилт зогсож сэнсэрнэ.

Иймд эрдэсийн бодис элбэгтэй витаминт ногоон өвс, таана, мангирын сорс хужир шүү, ясны нунтаг, зориулалт бүхий био бэлдмэлүүдийг байранд нь үргэлж байлгах нь чухал.

Төлд нарын гэрэл, цэвэр агаар чухал ач холбогдолтой.

Нарны гэрэл өвчний нягт устгаж төлийн мэдлэлийн төвийг сэргээж бодисын солилцоог сайжруулж арьсанд нь Д витамин бий болгоно.

Иймд төлийг наранд эзвэр дулаан саруул том тасалгаанд чөлөөтэй хөдөлгөн тоглуулах нь чухал. Ядарч доройтсон эх малын сүү шим татарч төл өлдөж үхэх, өсөлт торшилт нь зогсдог тул бэлчээрлүүлэх цагийг уртасгахад онцгой анхаарвал зохино.

Бөөм, ширх, хачиг хувалз биенд нь орох, хотны шар буун ам, хамраар нь чихэж уушгийг өвчлүүлэх зэргээс сэргийлж байвал зохино.

М.САМДАН

ТЭЭВЭРЧДИЙН АМЖИЛТ

Авто тээврийн XIII баазын тээвэрчид, шууданчид энэ оны 1 дүгээр улирлын ачаа эргэлт, тээх ачааны төлөвлөгөөг 122,6-139,4, хүн эргэлт, тээх хүний төлөвлөгөөг 125,9-537,5 хувиар биелүүлж парк, гүйлт, даац ашиг-

лах коэффициентийг 0,60—0,98-д хүргэв.

Аймгийн ачаа тонн км-ийн хошой аварга Ш. Готов, оны тээвэрчин Г. Чүлтэм, шууданч Ө. Шагдар, залуу тээвэрчин С. Шагдар, Х. Дагвадорж нар уралдаанд хошуучилж ял-
С.ОТГОН

ЦАГ УЕ МЭДЭЭ • ЦАГ УЕ МЭДЭЭ

Баяндэлгэр сумын 8 жилийн дунд суургуулийн пионерийн бүлгүүд «Хөдөлмөр-алдар гавьяаны хэрэг» гэсэн өндөр бүтээлийн ажил зохиож «Байдал» бригадын хоньчин Бадам, Ласран нарын суурьт очиж ямаа самнах ажилд тусалж 105 ямаанаас 40 кг ноолуур авч нэгдүгээр зэрэгт тушаав.

Энэ ажилд пионер Дорж, Д. Батхуяг, Төрбат, Батбаяр, Чулуундолгор нар идэвхтэй оролцов.

Б.БАЯРХҮҮ

Алтанбулаг сумын хэмжээгээр одоогийн байдлаар 21620 хониноос 21657 хурга, 1490 ямаанаас 1543 ишиг бүрэн мэнд бойжиж ихэр хурга 45, ишиг 63-тай байна.

Тус сумын «Алтан-овоо» бригадын Ц. Рэгзэнгийн суурь 214 хониноос 221 хурга, 88 ямаанаас 96 ишиг, Г. Нямдоогийн суурь 90 хониноос 90 хурга, 88 ямаанаас 96 ишиг бойжуулж байна.

Л.ДОЛГОР

Баян сумын «Цант» бригадын тэмээчин Гөлгөөгийн суурьт 70 гаруй нэгэ ботголохоос 52 нэгэ төллөж, төлөө 100 хувь бойжуулж байна.

Мөн Нина ахлагчтай бог малын суурийн төлчин Тамжид, Лхам нар 300 гаруй төл хүлээн аваад төлөө 103,4 хувь бойжуулж байна.

С.ЧАНЦАЛ

Эрдэнэ сумын «Гуяа» нэгдлийн «Хушинга» бригадын хоньчин Гомбын суурийнхан 40 хонигт үйлдвэрлэлийн даалгаварт бог малын сүү саах төлөвлөгөөгөө 105 хувиар биелүүлж 3700 литр сүү саасан байна.

Гомбын гэргий Цэрэнпэл хонь нэг бүрээс 12 литр, ямаа бүрээсээ 16 литр сүү саажээ.

Тэрээр энэ онд хонь бүрээс 15 литр, ямаа бүрээс 20 литр сүү ашиглах зорилт тавьж байна.

Д.ДОТГОН

Бүрэн сумын «Бүрэн-дэлгэр» нэгдэл энэ онд 3 суурь, 4 хэсэгт 90 нэгэнээс 90 ботго бойжуулах юм. Одоо 20 га-

руй нэгэ ботголож 100 хувь бойжиж байна.

Сумын эмэгтэйчүүдийн зөвлөл ингэний, суурийг хариуцаан авч суурьт 95 нэгнээ оройвч хийж өгч тусаллаа.

Ц.ТӨМБӨӨ

Борнуурын САА адуу дэлгэх 3 өдрийн сув-ботник хийж адууны хялгасны төлөвлөгөөг 100 хувь биелүүлэв.


Энэ ажилд САА-н захиргааны ажилтан Ч.Шонхор, Г. Жамъян, С. Дуламжав, сургуулийн ажилтан Сүхээ, Ж. Лхагва, Чимэдхал нар идэвхтэй оролцов.

Д.ДАШЦЭРЭН

Батсүмбэр сумын ХБА-гийн дэргэд СХБ 3, СХТБ 1 ажиллаж, нийт ажиллагсдын 95,6 хувь нь СХ-ийн хөдөлгөөнд хамрагдан СХТ анги болохоор 2 жилийн хугацаатай үүрэг авч, авсан үүргээ хугацаанд нь биелүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна.

Тус сумын ХБА-гийн ажилчин Пунсал, Цэнд нар улсын бэлтгэлд бодын туур 63 кг, шилбэний 180 кг-ыг тушааж 90 төгрөгийн хуримтлал орууллаа.

З.ОЧИРХУЯГ



Бүрэн сумын ХЗӨ-ийн залуучуудын гавштайч бригадын бүтээлч цуваанд «Булагга», Баянбулаг, Хайрхан бригадын залуучууд 70 гаруй тэмээ хужир шүү татаж идэвхтэй оролцжээ.

ЗУРАГ ДЭЭР: Ердийн хосгийн цувааныхан

Б. ТОГООХҮҮ, П. ЖАНЧИВ нарын авсан гэрэл зураг

БИРИЙН ТӨЛӨӨ

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, Ц. Жамсран Дэлгэрхаан сумын төлөөх малын сууриндаар орж малчин нэг бүрийн ажил байдал суурийн зохион байгуулалт «Малын зүй бус хорчидлыг багасгах» төл бийжуулах талаар гар ан МАХН-ын Төв Хорооны тогтоолын заалт нэг бүрийг хэрхэн ажил хэрэг болгож байгааг биечлэн шалгав.

Дэлгэрхаан сум энэ онд 21005 толгой мал төлүүлэхээс одоогийн байдлаар 13 мянга шахам мал

төлөж төл бойжилт 99,7 хувьтай байна.

Сумын хэмжээгээр зүй бус хорогдлоор 243 мал хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеэс төл бойжилт 31 хувь илүү, малын зүй бус хорогдол 41,3 хувиар багассан байна.

«Давст» бригадын (дарга нь Б. Намнан) 5 мянга гаруй мал төлөж нэгч төлийн хорогдол гараагүй ажээ.

Тус бригадын малчин Лувсандаш 460 хониноос 465 хурга, малчин У. Чоймбол, Д. Уртнасан нар төлөсөн эх малаас олон төл

илүү бойжуулж байгааг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга үзэж тэдгээр малчдын арга барилыг нийт малчдад эзэмшүүлэхийн чухлыг бригадын зөвлөлд үүрэг болгов. Гэвч энэ бригад зарим нэг малчдын хариуцлагагүйгээс болж

дал хашаа хороогоо тохиромжгүй байрлуулсан, мал нэг бүртгэх тавих хяналтыг сулруулсан, нэн ялангуяа малыг усаар хангах чухал ажилд хайхрамжгүй хандаж, бөөн бөөн нь шаваралдуулан оо нэрийн төдий усалж байснаас ядарч доройт-

дын сууриар орж ажилтай нь танилцав.

Энэ бригадын хэмжээгээр төлөх бүх малын 70 шахам хувь нь төлөж 32 төлийн хорогдолтой байв. Малчин А. Дагвадорж, Лувсандэмбэрэл, Бат очир нарын тэргүүний малчид олон байгаагийн гадна энэ бригадын 17 суурь «Энх сүрэгтэн», «Мэнд төлчин» суурь байгааг н. Ц. Жамсран сайшааж тэдгээр малчдад 1974 оныхоо ажилд өндөр амжилт гаргахыг ерөөв.

Мөн Дэлгэрхаан сумын төв хөдөөгийн малчид хөдөлмөрчид МАА-н мэргэжилтэн нартай уулзаж малын төлийг бүрэн мөнд бойжуулах, зүй бусын хорогдлыг багасгах, адуу тээмэний хариулга малаагаа тогтмолжуулж сайжруулахыг зөвлөв.

Я. ЦЭВЭГЧИР

АЖИЛТАЙ НЬ ТАНИЛЦАЖ ЗӨВЛӨВ

бригадын хэмжээгээр 143 мал хээл хаяж, 59 мал зүй бусаар хорогдсон байна.

Бүх хээл хаясан малын 94 нь хоньчин Шараагийн суурьт байгаа тул аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, хоньчин Шараагийн суурийн нэг өдрийн мал ажиллагааны байдлыг биечлэн шалгаж мал олноор хээл хаях яв-

сон, хээлгүй бага мал усаар их дутагдаж байсан нь хээл хаях үндсэн шалтгаан болжээ гэж үзээд хоньчин Шараад хээлгүй малын хээл хамгаалах ажлыг сайн хийх, мал маллагааны тэргүүний арга барилаас суралцахын чухлыг зөвлөв.

Мөн нөхөр Ц. Жамсран «Тарган» бригадын малч-

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗӨВЛӨЛГӨӨН

Аймгийн УААУГ-ын үйлдвэрлэлийн зөвлөгөөн саяхан болж 1973 оны үйлдвэрлэлийн ажлын дүн 1974 онд тавих зорилтын тухай хэлэлцэв.

Тус газар өнгөрсөн онд 100 гаруй уст цэг гаргаж 3 сая гаруй төгрөгийн үйлдвэрлэлийн программаа онд нь багтаан дуусгаж 90 гаруй хувийг нь сайнаас онц үнэлэлтэй ашигдалтанд өгч жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг ажлын төрөл бүр дээр нь 100—170 хувиар биелүүлж байгууллагын хэмжээгээр 378,2 мянган төгрөгийн ашигтай ажиллав.

Хэрийн үйлдвэрлэлийн бригад хэсгүүдийн дотор Дашдаваа ахлагчтай хөнгөн өрөмдлөгийн хайгуулын бригад төлөвлөгөөт ажлаа 30 хоногийн дотор 134,1—160 хувиар биелүүлж аймгийн аварга усжуулагч боллоо. Оюун

ахлагчтай гүн өрмийн бригад 12 худаг гарган, УААУГ-ны системээр аварга бригадын болзол хангаж диплом авчээ.

Тус зөвлөгөөнд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ц. Жамсран, аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга А. Давааням нар оролцов. Зөвлөгөөн дээр нөхөр Ц. Жамсран хэлэхдээ: Уст цэгийн барилга байгууламжийн төлөвлөгөөг биелүүлэхэд тооноос гадна чанарыг онцгой анхаарч хяналт шалгалтыг тогтмол явуулж ажиллах нь чухал. Өвөл, хаврын улиралд ашиглагдах бетон хашлагат ба богино индтан худгийн 15,2 хувь хөлдөж ашиглагдахгүй байгаа нь зохисгүй явдал юм.

Иймд уст цэгийн ашиглалтанд тооцоо судалгаа гаргаж хяналт тавих, юу-

ны өмнө худгийн засварын чанарыг эрс сайжруулах, мотормчин бэлтгэх, сумдын усны группүүдийг багаж төхөөрөмж запас сэлбэгээр хангаж группийн ахлагч, мастер нарын курс семинар зөвлөлтөөн хийх хэрэгтэй.

Мөн худаг бүрийг ашиглалтын тодорхой бүртгэлтэй болговол зохино.

Бас ажилчин, ажилтан нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхийн тулд ЗХУ-ын мэргэжилтнүүдийг дагалдан ажиллаж тэднээс их юм сурах, хэв журмын зөрчил гаргахгүй хамт олон байгууллага болох нь зүйтэй гэж зөвлөв.

Тус зөвлөлтөөнд 10 гаруй хүн үг хэлж үүрэг амлалт авсны дотор жоош Гончигсүрэн таван жилд 8 жилийн ажил хийх тооцоотой үүрэг авлаа.

Инженер Б. БАДАРЧ

Цагдан сэргийлэхэд туслах хүчний улсын II зөвлөлтөөний өмнө

НИЙГМЭЭ ГЭСЭН ЗҮТГЭЛ

МАХН-ын гишүүн Лувсанжамц Зуунмод хотын орон сууц гудамжны 6 дугаар хорооны 4 дүгээр хэсэгт хэв журам сахиулах ажлыг хариуцдаг.

ЦСБТОН-ийн бригадын гишүүн С. Лувсанжамц 1952 оноос эхлэн эдүгээ хүртэл энэ ажилд идэвхтэй оролцож хэв журам сахиулах, хууль дүрэм сурталчлах, эргүүл шалгалт хийх зэрэг ЦСБ-ын гадуур албаны олон талт ажилд мэргэжиж энэ талаар өөрийн гэсэн арга барил туршлагатай болсон хүн юм.

Зөвхөн сүүлийн 5 жилд 220 удаа 3080 хүн цагийн эргүүл шалгалт хийж 5150 хүнд хуулийн суртал ухуулгын ажил зохиожээ. Тэрээр өөрийн ажлыг, хамгийн нарийн судалгаа хийж, зохиох ажлаа шаардлагад тохируулан онож төлөвлөхөөс эхэлдэг байна.

Тэгэхдээ жилийн дөрвөн улиралд зохицуулан тухайлбал зун, намар ан агнуурын талаар, хавар намар гал түймрээс урьдчилан сэргийлэх тухай, үзвэр үйлчилгээний газар, орой, үдшийн цагаар хүүхэд залуучуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар, баяр ёслолын онцлог үсдийн амгалан, тайван байдлыг хангахад зохиох ажлынхаа голыг чиглүүлэн төрөлжүүлж төлөвлөдөг юм.

Гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил бол иргэн бүрийн, ялангуяа ЦСБТОН-ийн бригадын гишүүн хүний чухал үүрэг мөн гэж үзээд өөрийн хариуцсан газраа, нарийн судалгаа явуулж гэмт хэрэг хэв журмын зөрчилд өртөж болзошгүй хүмүүсийг хяналтандаа авч ахуй амьдрал, зан суртахуун ажил үйлийг нь нарийн

судалсны үндсэн дээр хэрэгт өртөгдөж болох тэр замуудыг хаах замаар хүмүүжүүлдэг байна.

Жишээ нь өнгөрсөн оноос эхлэн хэрэг зөрчилд өртөгдөж болзошгүй гэж бүртгэгдсэн Ж. Батсайхан, Б. Бадам нарыг даан хяналтандаа авч сургажлан хүмүүжүүлсний гадна өнчирч хоцроод асран тэтгэх ойрын төрөлгүүд Д. Наранццэг гэдэг хүүхдийг өөрийн гар дээр авч асран хүмүүжүүлж 7 дугаар ангийн нь сайн дүнтэй төгсгөсөн байна.

Энэ хүүхэд одоо ТМС-д суралцаж байгаа нь Лувсанжамц хүний төлөө хичнээн халамж тавьдгийн нэг жишээ юм. С. Лувсанжамц 1968 онд болсон туслах хүчнүүдийн улсын анхдугаар зөвлөлтөөнд шалгаран оролцож тэргүүний сайчуудын туршлагаас ихийг суралцжээ. Лувсанжамц ЦСБ-д туслах хөдөлмөрчдийн сайн дурын байгууллагуудын тэргүүний гишүүдийн улсын II зөвлөлтөөний боллыг хүлээн аваад өөрийн хариуцсан хороон дээрээ бригадын гишүүн Банзрагч, Жамбаа, Базарсүрэн нартай хамтран хууль сурталчлах үлгэр жишээ булан байгуулах, богино долгион радио станц хийх, 15-аас доошгүй ухуулах самбар хийж, онцлог газруудад тавьж ажиллуулах, хариуцсан хорооны олон нийтийн бригадыг тэргүүний залуучуудаар өргөтгөх, хууль дүрэм сурталчлах ба эргүүл шалгалтын ажилд тооцоо тоо бүртгэлийг нэвтрүүлэн ажиллахаар үүрэг аваад ажиллаж байна.

Одоо Лувсанжамц Цагдан сэргийлэхэд туслах хүчний II зөвлөлтөөнийг ажлын өндөр амжилтаар угтахын тулд чармайж байна.

Ю. НЭРГҮЙ



Бүрэн сумын Ж. Самбуугийн нэрэмжит „Бүрэндэлгэрэх“ нэгдлийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо төл ба эх мал тэжээлд зориулж хужир шүү гатах залуучуудын гавшгайч бригадын бүтээлч цуваа гаргаж бүх толчиддоо хужир шүү хангалттай болгөж өглөө.

ЗУРАГ ДЭЭР:

Залуучуудын гавшгайч бригадын тээвэрчдийн бүтээлч цуваа.

Б. ТОГООХҮҮ, П. ЖАНЧИВ нарын автан гэрэл зураг

АСГАТЫНХАН МИНЬ

Аги гангын аагсан үнэрт
Айраг таргийн шаагсан анирт
Сэрүүн шилийн Асгат минь
Сэтгэлд нэг л дулаахан
Сэмхэн будан дундаа
Сэмбийнэ үү дээ хө.
Хурган хэвнэг шиг торгон цасаа
Сэрвэн хярдаа сэгсрэн байдаг ч
Хонин чинээ хадан дундаа
Харзын ус нь харгатайхан
Хайлмаг цас нь морьдын сагагт
Хангинах хонх шиг шаргатайхан
Талын чинээ хашаан дотроо
Намрын өвс нь аагтайхан
Тавиллага цагаан уулан дундаа
Малын палай жаргалтайхан
Уугуул суугуул нутагтаа
Зудын хайрууг халгаагүй
Улаан үнэгэн малтайгаа
Зуурдын жаварт буулгаагүй

Манай нутгийн малчид чинь
Сайхан хаврыг угтаад
Хөөрөг тамхна солонхон
Хөөрөн догдлон байгаа даа
Арцат тайгын үнэртэйхэн
Уурын зэрэглээ мяралзсан шиг
Аржийн таржийн цаснаас нь
Өвсний собо ногоорсон шиг
Яг өдийд тортогт хөх Асгат минь
Яргуй нөмрөг намнулчихсан
Бэлд нь өвөлжсөн манайхан
Талд нь буугаад хаваржаалчихсан
Хадлан дэжээл данагар болохоор
Сэтгэл гэдэг ханагар байгаа.
Уяхан бүүвэй нарныхаа
Уртхан гэрлийг хэмжингээ
Хүчин өвийн чадлаар
Нэгдэл маань ч тохижиж
Талаар тэлхсэн сүрэг маань
Ихрээр голцуу үржсэн гэж
Танагтай хөгшидийн халаа
Илгээлт аваад ирсэн гэж
Ус голын хэн маань

Учруут надад хөөрөв шүү.
Нэгдлийн аварга бригад болоод
Нижгэр наадам хийсэн шиг
Сандаг өвгөний цавдар морь
Саахалтын тэртэй түрүүлсэн шиг
Хүрэм тайгын Асгатынхан
Хүндэт алдраа дуурсгасан шиг
Он цагийн уралдаанд
Одтой яваа гэлцэх юм.
Малынхаа хашаанд чийдэн тавьчихаад
Манайхан баахан догдолсон гэнэлэй
Алтан хүрээтэй шилээ зүүчихээд
Анжаа, зурагтаас салдаггүй гэнэлэй
Жигүүртэй морьд шиг өдөр хоног нь
Жилээс жилд өнгөжих юм даа
Сэтгэл сэргээх өнгө бүхэнд нь
Зүтгэл чадал чинь шингэсэн юм даа
Өнөр өтгөн ард түмний минь
Өгөөмөр жаргалын нэгэн далай
Сэрүүн шилийн Асгат минь
Сэтгэлд нэг л дулаахан
Сэмхэн будан дундаа
Сэмбийсээрээ хө.

Ш. ЦЭРЭНДОО

УРТЫН ДУУ ШИГЭЭ МИНИЙ АРД ТҮМЭН

Уужим хорвоод хувь нэгтэй
Уртын дуу шиг
Миний ард түмэн
Дуулим хорвоод энэ биеий минь та
Дуу шиг амьдралд өсгөө билээ.
Сайхан дуу шиг амьдралдаа би
Санаа цэлмэн өсөө билээ.
Мөнх орчлонгийн саран гэмээр
Мөндөр цагаан гэртээ гэвэл
Тансаг дэлхийн мишээл баймаар,
Талын айлын найранд гэвэл
Уяхан замбуутивийн цээл аялага
Ухаан санаанд орчлонг ярьсан юм.
Дуусашгүй ухаант аавынхаа үгийг
Дуунаас бас гхиж чагнасан юм.
Хүний орчлонд дуу байдаг
Хүү минь, түүнийг сурч ав гэлээ.
Дуун шууранхайлах энэ хорвоод
Буун дуу бас байдаг
Дуунаас түүнийг мэдэж ав гэлээ.
Өргөн хорвоог ухаажуулах
Тийм сайхан дуугаан
Өнчин хүү боловч

Найрын хоймор дуулна-
Хүн болгон дуулах
Монгол газар минь ингэж
Хүнгэнэснэн хуур шиг
Уртын дуутай нөхөрлөнө.
Шингэн лимбийн хоолойгоор
Дээдэс аялсан дууг -
Шинээ хнагтаар түрсэн
Миний ард түмэн
Дуусашгүй дуу шигээ
Аяс тавиун нутагтаа
Дундрашгүй жаргалыг өнөөдөр
Дуун хуураар бүтээгээ билээ.
Хүрэх газар минь
Хүний ертөнцийн дуу.
Эгшиг дуун хурдаар
Эх орон минь дөтөлсөн.
Эв хамт билээ.
Дуулим хорвоод энэ биеий минь
Дуунд умбуулж ухаажуулсан
Уужим хорвоод хувь нэгтэй
Уртын дуу шиг
Миний ард түмэн

САРНЫ ШОРОО

Сарны шороо үзье гэж
музайд очлоо
Саарал нунтаг
шилэн хоргонд харагднам
Мөнгөн туяагаа
орчлонгоор цацдаг сарных
Мөн үү энэ? гэж
гайхмаар үзэгдэнэ
Шижир наран жаргасан
шөнө дөлөөр
Ширхэг сувд гэсэн ч
олж болмоор гэгээтэй
Галт шил мэт
нарны туяаг ойлгож
Газар дэлхийд түүнээ
гэрлэн дохио шиг илгээх
Хол ертөнцийн шороо

Хоргонд байгаа нь энэ гэгэм
Хөөрөгтэй тамхи шиг
нунтаг атлаа
Хөх аргалын
үнс шиг саарал
Өөр ертөнцийн
хөрс гэтлээ
Өссөн нутгийн минь
газар шиг дотно
Сав ертөнцийн нүд булаасан
Сарны шороо өмнө минь байна.
Ойртох тутам бараахан мөртлөө
Ойх гэгээ нь дун цагаан
Одон гаригийн зайтай хирнээ
Одоогийн хүнд айлын чинээ
Холын сарны шороон дээр би
Хорвоогийн хүний мөрийг үзэв.
Өөр гаригийн шороог үзээд
Өөрийн дэлхийн сууд бишрээв.

Д. ЦООДОЛ



ҮХЭР СҮРЭГ.

Л.ГҮНГААБУУ-гийн авсан судалбар гэрэл зураг



ХЭРЛЭН БАЯН УЛААН

Эртийн дээрээс алдартай Хэрлэн баян улаан минь
Эгнээ мялган уулсын халуу дүүгсэн өвөлжөөд минь
Эцгийн минь илбэнх дээл шиг илчтэйхэн билээ л
Ээжийн минь ариухан хайр шиг ивээлтэйхэн билээ л
Уулан дундаа буудалтай мянган дулаан бууцанд чинь
Улирах хичнээн үед манайхан идээшиж
Ундармал усан эхтэй зуун голын хөвөөнд
Уртын тууврыг давсан буянт малаа налайлгаа бол,
Уран хуурын эгшгээ хэдий үеэс хангинуулж
Уулархаг Хэрлэн баяныг магтан дуулаа бол,
Мөнгөн баавар шиг цавцайх цагаан гэрээ шийрлэж
Мөсөн ташуур шиг жаврыг өн таргаар даваад
Уул их түүхийг нүүж туулсан ардын минь
Ухаант хөдөлмөрөөр шалгарсан нүүдлийн урт замууд
Миний өвөг дээдсийн тэмцэл хөдөлмөрийг түүхчилсэн
Мянган бууцандаа голомттой Хэрлэн баян улаан минь
Мөнх ноёдох сардгийнхаа тэнүүн бэлээс ундарсан
Мөрөн Хэрлэнгийн дүү хээрийн зуун голууд минь
Эцгийн минь илбэнх дээл шиг илчтэйхэн билээ л
Ээжийн минь ариухан хайр шиг ивээлтэйхэн билээ л

Г. ДАШРЭНЦЭН

ӨГЛӨӨНИЙ НАРАН

Тоост талын хаяанаас наран мандахдаа
Тоонын шунхан дааганд алтан туяагаа мялааж
Тохилог цагаан харшийн цонх шилийг гялбуулж
Торомгор бяцхан үрий минь инээд баяслаар өндийж
Наашлан наашлан мандахдаа хосгүй илчээр ивээн
Наран гэрлийн жаргалдаа хорвоог бүхлээр нь умбуулж байна

Алиман сарны зүүрмэглэгч зүйдэлгүй тэнгэрийн дор
Амгалангийн бүүвэй аялж хорвоо дэлхийг амраан
Аугаа маргаашийн төлөө тэмүүлэл зоргий нь хөвчилсөөр
Ажил бүтээлийн төлөө тэнхээ чадлы нь нэмсээр
Өчигдрийн орхисон алжаалыг шөнний харанхуйтай тууж
Өнөө өглөөний наран манай баяртай мандаж байна.

Н. ЛХАГВАСАРЭН

Аман зохиол сонирхогчийн тэмдэглэлээ

ЗАНГУУНЫ ҮЛГЭР

Ажил муутай эр эм хоёр айл болон амьдардаг байжээ. Нөхөр нь нэг өдөр, За хө зангуу тарьдаг хэрэг гэж гэнэ. За яаж байгаа нь тэр билээ гэсэн чинь айлд хонь зангуун дундуур бэлчэхээрээ ноосноосоо наатдуулчихдаг юм байхгүй юу, тэр ноосны нь түүгээд эсгий хийдэг хэрэг ээ гэв.

Эхнэр нь эсгийгээ яах вэ гэхэд мань эр, гүүнээс арилжина гэжээ. Хөөрхий баярласан эхнэр нь тэгвэл би түүгээ унага гэхлээр Чи хээлтэй гүү унаж унага халуулах гэв юу гээд нөхөр нь эхнэрээ зодчихож гэнээ.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь
жилдээ

№ 27 (2291)

1974 оны 4 дугаар сарын 4

ПҮРЭВ

УЛСЫН БЭЛТГЭЛИЙН ЧУХАЛ ХЭСЭГ

Төлөвлөгөөт 5 жилийн эхний 3 жилд бодын хөөвөр, хялгас, ямааны ноолуур бэлтгэх ажлыг Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцогт, Борнуур, Заамар, Угтаал, Эрдэнэсант зэрэг сумд жил бүр давуулан биелүүлжээ. Үйлдвэр баазд тушаасан ямааны ноолуурын 75,3—81,7 хувь нь сүүлийн 3 жилд 1, 2 дугаар зэргийн чанартай тушаагдсаны дотор Баян, Сэргэлэн, Бүрэн, Эрдэнэсант, Борнуур сумдын бэлтгэсэн бүх ноолуурын 82—100 хувь нь 1, 2 дугаар зэргийн чанарт хүрчээ.

Энэ нь ямааны ноолуур, бодын хөөвөр, хялгас бэлтгэх ажилд цаг алдаагүй орж ямаа самнах, бод мал хөөвөрлөх хүмүүс ба уг суурийн ахлагч нарт сайн чанарын ноолуур, хөөвөр, хялгас бэлтгэхийн эдийн засгийн ач холбогдол арга ажиллагааг урьдчилан семинарлаж түүний явцад тавих хяналт шалгалтыг сайжруулан, социалист уралдааныг өрнүүлэн дасны үр дүн мөн.

1974 онд манай аймаг хөөвөр 66,2, хялгас 90,6, ноолуур 43,4 тонн бэлтгэж улсад нийлүүлэх юм.

Энэ даалгаврыг биелүүлэхэд малын зүй бусын хорогдлыг багасгах зарим арга хэмжээний тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор бодын хөөвөр, хялгас бэлтгэх ажлын технологи, төлөвлөлтийн хэмжээг өөрчилсөн заалтыг хэрэгжүүлэн биелүүлэхийн тулд нөөц бололцоог дайчлан ашиглаж онц эхэнд байсан үхэр, адуу нэг бүрээс дунджаар хөөвөр 285 грамм, хялгасадуунаас 366 грамм, үхрээс 50 грамм, ноолуур ямаа бүрээс 267 граммыг авч ашигласны үндсэн дээр улсын төлөвлөгөө, уралдаанд авсан үүргээ ханган биелүүлэх юм. Иймд сум, суурь, бригад бүр энэ ажлыг нарийн шуурхай зохион байгуулж богино хугацаанд хийж дуусгах хэрэгтэй.

Бодын хөөвөр, хялгас, ямааны ноолуур бэлтгэх ажлыг орон нутгийн нам, улс, ХАА, худалдаа бэлтгэлийн зарим байгууллагууд цаг алдаж оройтуулах, зохион байгуулалт, хяналт шалгалтын ажлыг дутуу хийж уг ажилд хайхрамжгүй хандаж их хэмжээний зогсонги ажил үүсвэрийг алдан, улсын төлөвлөгөөг таслах зэрэг ноцтой дутагдал гарч байсны улмаас сүүлийн 2—3 жил дараалан бодын хөөвөр, хялгас, ямааны ноолуур бэлтгэх улсын төлөвлөгөөг Дэлгэрхаан, Лүн, Баянзүрх, Баян, Баянцагаан, Алтайбулаг зэрэг сумд тасалжээ.

Дотоодлоо байгаа нөөц бололцоог муу ашиглаж улсын төлөвлөгөөт даалгавар уралдаанд авсан үүргээ тасалдуулж байгаа явдалд хатуу дүгнэлт хийж МАХН-ын Төв Хорооны 1973 оны VII бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн төлөвлөгөөг үзүүлэлт нэг бүрээр биелүүлэхийн хамт өнгөрсөн 3 жилд тасалдуулсан зүйлээ нөхөн биелүүлэх арга хэмжээ авах нь холбогдох сумдын өмнө чухлаар шаардагдаж байна. Бодын хөөвөр, хялгас, ноолуурын төлөвлөгөө бүрэн биелүүлэхэд ХАА, худалдаа бэлтгэлийн байгууллагын хамтын чармайлтыг өрнүүлж ноос бэлтгэлийн ажлын явцад тавих хяналтыг тогтмолжуулан чанаржуулахад орон нутгийн нам, улсын байгууллагууд зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч энэ ажлын ач холбогдлыг сурталчлан социалист уралдааныг өрнүүлэн тэргүүн туршлагыг дэлгэрүүлэх ажлыг эрчимтэй зохиох нь чухал.

Тэрчилэн малын ноос үсийг авсаны дараа цуглуулан тушаах, анхан шатны ялгаат тордлого хийх, элдэв бохирдлыг цэвэрлэх ажлыг чанартай хийж, ноос бэлтгэлийн стандартын шаардлагыг бэлтгэх, авах, тушаах ажлын дамжлага бүрт ёсчилон биелүүлбэл зохино. Бодын хөөвөр, хялгас, ямааны ноолуур бэлтгэх ажилд залуучууд, эмэгтйчүүдийн зэрэг олон нийтийн байгууллагуудын хүчийг бүрэн чиглүүлж, хүн хүчээр дутмаг сууриудыг шөвлөн авч туслах явдал чухал байна. Бэлтгэгдсэн хөөвөр, хялгас, ноолуурыг түргэн тээвэрлүүлэхэд худалдаа, тээврийн байгууллагууд их анхаарч ажлаа нягт холбон зохиох хэрэгтэй.

ШАГНАЛ ГАРДУУЛАВ

Бүх ард түмний социалист уралдааны жил—1973 оны ажилд өндөр амжилт гаргасан зарим ажилчдад шагнал гардуулах цуглаан НААУ-ний газар, «Анхдугаар таван жил» сонин үйлдвэр дээр болов.

Тус цуглаанууд дээр «Социалист уралдаанд түрүүлэгч» тэмдгээр шагнагдсан НААУ-ний газрын гуталчин Д.Дашпэрэн, оёдолчин Х.Аюуш, төмөрчин Г.Банзрагч, сонин үйлдвэрийн үсэг өргөч Д.Лхагва, дэвтэрлэгч Догоосүрэн нарт уул шагналыг аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Н.Шагдардагва гардуулав.

Мөн хивсэн тасгийн мастер Жамсран МҮЭ-ийн Төв Зөвлөлийн зардлаар дотоодын амралтанд 14 хоног амрах эрхийн бичгээр шагналав.

Д.ХИШИГЧУЛУУН

Социалист уралдаанд

Борнуурын САА-н саалийн 5 дугаар бригадын малчдаас 1974 онд аймгийн бүх ферм, бригадуудыг социалист уралдаанд уриалж авсан үүрэг

—Бэлчээрийг хуваарьтай ашиглан малчарчилгаа, маллагаа сайжруулж сүүлийн 3 жилд гарсан том ба төлийн зүй бусын хорогдлыг 50 хувиар бууруулж, мал өсгөх төлөвлөгөөг 101 хувиар биелүүлнэ.

—Аймгийн намын хорооны VI бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн 100 эхээс 90 тугал бойжуулна.

—Нутгийн үүлдрийн үнээ бүрээс 1100 литр сүү сааж улсад 175600 литр сүү тушааж, 1974

оны сүүний төлөвлөгөөг 12 дугаар сарын 25-ны дотор 5268 литрээр давуулна.

—Үнээ бүрээ гардан хээлтүүлж, хуанлийг нарийн хөтөлж үнээний хээл хаялт, сувайралтыг гаргахгүй байна.

—Үхэр бүрээс хөөвөр 560 граммыг ашиглаж төлөвлөгөөг 5 дугаар сарын 1-ний дотор биелүүлнэ.

—Өвлийн бэлтгэлийг 3 үе шаттай явуулдаг Завсхан аймгийн Цэцэн-уул сумын туршлагыг ажил-

даа нэвтрүүлж 100 тонн бууц нөөцөлж хадгалгын төлөвлөгөөг 101 хувиар биелүүлнэ.

—Бригад суурьт хөтөлгөдөх анхан шатны бүртгэл тооцоог бүрэн нэвтрүүлж малчин, саальчин бүр хувийн тооцоот үүрэгтэй ажиллана.

—Суурийн хүмүүжлийн ажлыг чанаржуулж 16 хүн боловсролоор шат ахиж бригадаараа зоомал эмнэлгийн анхны мэдэгдэхүүн эзэмшинэ.

—Бригадаараа социалист хөдөлмөрийн хөдөлгөөнд хамрагдан ажиллана. Улаанбулангаа тохижуулж соёл урлагийн төв болгон, гэмт хэрэг зөрчилгүй хамт олон болж ажиллана.

Бригадын хамт олон

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 4 дүгээр сарын 2-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 45,7 хувь буюу 294,6 мянга нь төлөж гарсан төлийн 99,3 хувь буюу 295,5 мянган төл бойжиж байна. САА-нуудад гарсан төлийн 98,8 хувь буюу 35,9 мянга нь, ХААН-үүдэд гарсан төлийн 99,5 хувь нь буюу 227,6 мянга нь, ТАА-нуудад гарсан төлийн 99,7 хувь нь буюу 3,5 мянга нь, амины аж ахуйд гарсан төлийн 99,8 хувь нь буюу 28,5 мянга нь бойжиж байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүлбэл:

Сумдын нэрс	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баян-өнжүүл	100,0	1
Эрдэнэсант	100,0	2
Баянцагаан	100,0	3
Угтаал	99,9	4
Алтанбулаг	99,9	5
Баян	99,9	6
Баянцогт	99,9	7
Лүн	99,8	8
Дэлгэрхаан	99,7	9
Өндөрширээт	99,7	10
Баянжаргалан	99,7	11
Баянчандмань	99,5	12
Борнуур	99,5	13
Баянзүрх	99,4	14
Эрдэнэ	99,4	15
Сэргэлэн	99,4	16
Батсүмбэр	99,3	17
Баяндэлгэр	98,8	18
Бүрэн	98,6	19
Мөнгөнморьт	98,2	20
Заамар	98,1	21
Жаргалант	96,4	22

Статистикийн товчоо

ЭХНИЙ АРАВ ХОНОГТ

Баянцагаан сумын «Өр-БНМАУ-ын аварга төлчин нөх-амьдраг» нэгдлийн Д.Гонгор 220 хонь, ямаа «Гурван түрүү» бригад төлүүлж 15 ихэр төл илүү төлчдийн дунд зарласан бойжуулж 1 дүгээр байр уралдааныхаа эхний 10 хоног эзэлж шилжин явах туг нөгийг дүнг гаргахад мөнгөн шагнал, 12—14 2011 хонь, 525 ямаа төл ихэр төл бойжуулсан гэж 2096 хурга, 570 ишиг Намсрай, С. Дамдинсүрэн буюу 85 хурга, 45 ишиг нар 2,3 дугаар байранд ихэр байна.

Арав хоногийн уралдаанд

Х.ДОВДОНЧУЛУУН

Амжилтаа бататгана

Баянзүрх сумын «Сүхбаатарын зам» нэгдлийн «Баян-бүрд» бригадын хоньчин Б.Равжир 7 дугаар анги төлсгөж өөрийн хүсэлтээр мал аж ахуй дээр гарч хоньчин болсноос хойш 3 жил өнгөрчээ.

Тэрээр 1973 онд суурнараа эм хонь 547, эм ямаа 75-ыг төлүүлж, төлөсөн малаас хурга 10, ишиг 5-ыг илүү бойжуулжээ.

Мөн уртын ноос, ноолуур, сүүний төлөвлөгөөг 100—114,2 хувь биелүүлж 10-аад удаа нүүж дунджаар эм хонь 56 кг, эм ямааг 55 кг таргалуулжээ.

Б.Равжир ярихдаа: Төлөх дөхсөн малыг тусгаарлан нэмэгдэл тэжээлд оруулж эх малд тарга хүч сайн авахуулах нь гарсан төл эрүүл чийрэг эх нь жилбэ сайтай төлөдөг.

Хаврын цагт жилбэ муутай төлөсөн ядарч доройтсон эх малд нэмэгдэл тэжээл адууны мах ясны шөл өдөрт 200—250 мл-лтр, агь болон сайн чанарын өвсний ханд 1 литр, сонгинын таташны шүүс 300—500 мл-лтр, адууны элэг бага багаар өгөх нь сүү, жилбэ оруулж тэнхэ рүүлдэг.

Энэ жил төлийн бэлтгэлд зориулж хашаа, хороогоо засварлан өвс тэжээл татаж, элгэвч 54, нэмээ 160-ыг бэлтгэлээ.

Он гарсаар малын зүй бусын хорогдол гаргаагүй төл сайн бойжиж байна.

Урд оны амжилтаа улам бататгана гэж ярих.

С.ГАЛДАНЖАМЦ